



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/403

Чингис хот

Дадлага сургалт зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 2844 дүгээр албан бичиг, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтран баталсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний багийг бэлтгэх сургалтын удирдамжийн дагуу аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт зөвлөгөө өгөх, үүрэг гүйцэтгэх шуурхай хариу арга хэмжээний баг томилох, бие бүрэлдэхүүнийг чадавхижуулах сургалт, дадлагыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардлыг тооцож олгосугай.

2. Зардлын төрөл, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3. Дадлага сургалтыг зохион байгуулахад шаардагдах 4479650 /дөрвөн сая дөрвөн зуун далан есөн мянга зургаан зуун тавин/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010845

Аймгийн Засаг даргын 2020 оны
12 дугаар сарын 11 өдрийн А/1493
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл					Дүн
		Хоол	Холбоо /интернет/	Самбарын үнэ	Газрын зураг	Бичиг хэргийн зардал	
1	Онцгой байдлын газар	581500	52250	2830000	240000	775900	4479650
	Дүн	581500	52250	2830000	240000	775900	4479650